*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

ДАЙЧИЛГААНЫ ОФИЦЕР ХОШУУЧ ГЭРЭЛХҮҮГИЙН МӨНХБАЯРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Цэргийн штаб

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| НЭГ. “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлэх" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1. Батлан хамгаалах чиглэлээр гарсан** хууль тогтоомжийн биелэлтийг хангах ажлыг орон нутагт зохион байгуулж хэрэгжүүлэх; нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд батлан хамгаалах төрийн үйлчилгээг үзүүлэх ажлыг мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх | 60 | 10 | 70 | |
| 2. | **Дэд арга хэмжээ – 1.1.1:** Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлах | 60 | 10 | 70 | |
| 3. | **Дэд арга хэмжээ – 1.1.2:** Батлан хамгаалахын хууль тогтоомж, тушаал, шийдвэр, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах | 60 | 10 | 70 | |
| 4. | **Дэд арга хэмжээ – 1.1.3:** Зэвсэгт хүчний 104 жилийн ой, “Халх голын байлдааны ялалтын 86 жилийн ойн” баярын арга хэмжээг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, сурталчлах; | 60 | 10 | 70 | |
| 5. | **Дэд арга хэмжээ – 1.1.4:** Аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг зохион байгуулах, шалгарсан баг тамирчдыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | “Дөл” цогцолбор тэмцээнд оролцуулах. | | | | |
| ХОЁР “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дайчилгааны төлөвлөгөөг шинэчилж, иргэд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагуудад шалган туслах ажлыг зохион байгуулж, иргэний цэргийн үүргийн биелэлтийг хангуулна” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1.** Дайчилгааны нөөцийг тооцох, дүн шинжилгээ хийх, мэдээ судалгааг цаг тухайд нь гаргаж танилцуулах, хугацаат албаны цэрэг татлагын ажлыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 2. | **Дэд арга хэмжээ – 2.1.1:** Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх төлөвлөгөө, Орон нутгийн цэргийн төлөвлөгөөнүүдэд оногдуулан бүртгэгдсэн хүн, техникийг дайчилгааны даалгаврын дагуу тогтоосон хугацаанд татан нийлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, дайчилгааны томилгоот бүрэлдэхүүн, хүч хэрэгсэлд тодотгол хийх | 60 | 10 | 70 | |
| ГУРАВ. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | |
| 1. | Цэргийн сургуульд элсэн суралцах хүсэлтэй иргэдийг сонгон шалгаруулж элсүүлэх | 60 | 10 | 70 | |
| 2. | Аймгийн ЗДТГ-аас зохион явуулсан цаг үеийн үйл ажилд оролцох, орон нутагт томилолтоор ажиллах. | 60 | 10 | 70 | |
| 3. | Орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцох. | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | 70 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | **Арга хэмжээ 1.** БХЯам, ЗХЖШ-аас зохион явуулахаар төлөвлөгдсөн мэргэжлийн сургалтуудад тушаалын дагуу хамрагдах. | 70% | 10,5 | |
| 2. | **Арга хэмжээ 2.** Цэргийн хэргийн мэдлэгийг дээшлүүлэх. | 100% | 15 | |
| **Дундаж оноо** | | | 12.7 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 6 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 6 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 6 | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | 6 | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | 6 | |
| **Дундаж оноо** | | 6 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6 |
| 2. | Багаар ажиллах | 7 |
| 3. | Харилцаа | 7 |
| **Дундаж оноо** | | 6.6 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт** *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 70 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 12,7 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(7 хүртэлх оноо)* 6 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 6.6 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* 953 |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | |

*Үнэлгээ өгсөн:* *Нэгжийн дарга*

ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА ........................ /Д.ТӨМӨРБААТАР/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.05 *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***

ДАЙЧИЛГААНЫ ОФИЦЕР ХОШУУЧ .............................. /Г.МӨНХБАЯР/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.05 *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА /Д.БУЯНХИШИГ/

ХШҮХ - дарга .............................. /Д.Буянхишиг/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.11 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

*ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН* /Ч.НЯНДАГ/

.............................. .............................. /.............................../
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.11 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ЗДТГ-ЫН ДАРГА .............................. /Ш.ЭРДЭНЭБАТ/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.15 *(огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБЫН ДАЙЧИЛГААНЫ ОФИЦЕР
ХОШУУЧ ГЭРЭЛХҮҮГИЙН МӨНХБАЯРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.** Батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн биелэлтийг хангах ажлыг орон нутагт зохион байгуулж хэрэгжүүлэх; нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд батлан хамгаалах төрийн үйлчилгээг үзүүлэх ажлыг мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлах | Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучууд тодорхой түвшний мэдээлэлтэй болсон байх | Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Говь-Алтай аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний дагуу иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, орон нутагт батлан хамгаалах бодлого, зорилт, зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлах, Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ой, Монгол цэргийн өдрийн хүрээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэй албан хаагчдын дунд мөрдөстэй бүсгүйчүүд чуулга уулзалтыг Алтай сум дахь Хилийн цэргийн 0214 дүгээр ангид зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн санаачилгаар 2025 оныг "Ахлах офицерын жил" болгон | Тухайн жилд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зарласантай холбогдуулан Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойн хүрээнд “Цол бүхэн сайхан” нэрэмжит тэмцээн, марш-тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг, бүлэг шалгаруулах тэмцээн болон “Засагт хан” буудлагын холбоотой хамтран энгийн иргэдийн дунд буудлагын 3 төрөлт тэмцээн, ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд автоматын задаргаа, угсаргаа, магазин сумалгааны тэмцээнийг тус тус зохион байгуулсан.<br>Өсвөр үе, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, Монголын уламжлалт ёс заншил, зан үйл, тоглоом наадгайг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, сурталчлан таниулах, түүх, соёлын өвийг хамгаалах, Монгол хувцасны соёлыг түгээх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Эх оронч Монгол-Өвлөн наадъя" арга хэмжээг аймгийн Боловсролын газар, Соёл урлагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж явууллаа. Тус тэмцээнд аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийн 7 баг оролцлоо.<br>Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ой, Монгол цэргийн баярын өдрийн хүрээнд Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Алтай телевизтэй хамтран "Хугацаат цэргийн алба хаагчийн нэг өдөр" баярын тусгай | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дугаарын контентыг хийж иргэдэд хүргэсэн.<br>"Алтай" чуулгын уран бүтээлчидтэй хамтран "Эх орон" хүндэтгэлийн тоглолтыг зохион байгуулж Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлан ажилласан.<br>Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын ахлах офицерын чуулга уулзалт"-ыг угтан ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Эх оронч үзэл-Үндэсний бахархал" сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг зохион байгууллаа. Тус уралдаанд аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн 27 сурагч оролцлоо. | | |
| 2 | Арга хэмжээ 1.2. Батлан хамгаалахын хууль тогтоомж, тушаал, шийдвэр, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Батлан хамгаалахын хууль тогтоомж, тушаал, шийдвэр, албан даалгаврын хэрэгжилтийг хангах | Батлан хамгаалахын хууль тогтоомж, тушаал, шийдвэр, албан даалгаврын хэрэгжилтийг хангагдсан байх | Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион явуулсан сумдын удирдах бүрэлдэхүүнийг чадавхжуулах сургалтын хүрээнд Монгол Улсын дайчилгааны тухай хууль, Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг орон нутагт 2025 онд хэрэгжүүлэхээр Батлан хамгаалахын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 2.1.5, 3.2 дахь хэсэг, Батлан хамгаалахын сайдын 2020 оны "Цэргийн бэлтгэл сургалтын хөтөлбөр батлах тухай" А/121 тоот тушаал, цэргийн штабын 2025 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөг тус тус мөрдлөг болгон багийн Засаг | Тухайн жилд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг хамтатган зохион байгууллаа. Сургалтаар Батлан хамгаалахын сайдын 2020 оны “Цэргийн сургалт бэлтгэлийн хөтөлбөр батлах тухай” А/121 дүгээр тушаалаар батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан нийт 24 цагийн сургалт бэлтгэлийг зохион байгууллаа.<br>Сургалтаар батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх, цэргийн штабын бэлэн байдлыг хангах, дайчилгааны бэлтгэл нөөцийн болон орон нутгийн хамгаалалтын сургалт бэлтгэлийн хангах, томилгоот бүрэлдэхүүнийг тодотгож үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх асуудлуудын хүрээнд мэдээлэл өгч, хууль эрх зүйн зохицуулалт, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах арга зүй, анхаарах асуудал, гамшгийн үеийн холбоо, зарлан мэдээлэл дамжуулахад анхаарах асуудал, ажлын байрны сэтгэлзүй, батлан хамгаалах бодлого, дадлага ажлыг явуулж санал хүсэлтийг сонсож, нэгдсэн ойлголтод хүрч цаашид анхаарах зарим чиглэлийн талаар үүрэг өгч “Төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг бие бүрэлдэхүүнд танилцуулан нууц хадгалалт хамгаалалтыг чанд мөрдөх, урьдчилан сэргийлэх талаар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зааварчилгаа танилцуулан ажилласан.<br>Сумдад батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт, иргэний цэргийн үүргийн биелэлтэд хяналт тавих, сумдын дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилт, тодотгол хийсэн байдал, хадгалалт хамгаалалт, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ажилладаг 18-55 насны цэргийн үүрэгтний цэргийн үүргийн биелэлтэд хяналт шалгалтыг явуулж зөрчилтэй иргэдийн зөрчлийг арилгуулах, цэргийн албатай холбоотой төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах арга хэмжээг 2025 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагатай хамтатган зохион явууллаа. | | |
| 3 | Арга хэмжээ 1.3. Зэвсэгт хүчний 104 жилийн ой, "Халх голын байлдааны ялалтын 86 жилийн ойн" баярын арга хэмжээг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, сурталчлах; | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Зэвсэгт хүчний 104 жилийн ой, "Халх голын байлдааны ялалтын 86 жилийн ойн" баярын арга хэмжээг тусгай төлөвлөгөөг боловсруулах | Зэвсэгт хүчний 104 жилийн ой, "Халх голын байлдааны ялалтын 86 жилийн ойн" баярын арга хэмжээг тусгай төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байх | Батлан хамгаалах салбараас 2025 оныг "Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил" болгон зарласантай холбогдуулан Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойн, Монгол цэргийн өдрийн хүрээнд тус аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас 18 ажил, арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн 03 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд зохион байгууллаа.<br>Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа зэвсэглэл, техник, | Тухайн жилд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | багаж хэрэгслийн үзэсгэлэн дэлгэн иргэдэд сурталчилсан.<br>Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд Марш-тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг, бүлэг шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. Тус тэмцээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эрэгтэй 8 тасаг, эмэгтэй 4 тасгийн 112 тамирчин оролцлоо.<br>Хилийн цэргийн 0214 ангитай хамтран Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэй алба хаагчдын "Мөрдөстэй бүсгүйчүүд" чуулга уулзалтыг зохион байгуулсан.<br>Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний<br>Ерөнхий командлагчийн санаачилгаар 2025 оныг "Ахлах офицерын жил" болгон зарласантай холбогдуулан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд "Цол бүхэн сайхан" нэрэмжит дартс, ширээний теннис, буудлагын тэмцээнийг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 11 цолны 44 алба хаагчд өрсөлдөж аваргуудаа шалгаруулсан. "Засагт Хан" буудлагын холбоотой хамтран энгийн иргэдийн дунд буудлагын тэмцээнийг том калибр, дурантай бага калибр, ил хараа гэсэн 3 төрлөөр явуулж аваргуудыг шалгарууллаа.<br>Аймгийн биеийн тамир спортын газар, Есөнбулаг сумтай хамтран Алтай хотын аварга шалгаруулах бөхийн барилдааныг зохион байгуулж барилдаанд 56 бөх барилдлаа. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн болон Мэргэжлийн боловсролын сургуулийн сурагчдын дунд “Галын бэлтгэлийн норматив”, “Магазин сумалгаа”-ны тэмцээнийг зохион байгууллаа.<br>“Чөлөөлөх дайн”-ны 80 жилийн ойн хүрээнд Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2025 оны А/159 дүгээр захирамж, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 1в/2799, Төрийн захиргааны удирдлагын газрын даргын 04/3028 дугаар албан бичгийн дагуу Батлан хамгаалах яамнаас зохион байгуулсан “Эх оронч Монгол” нээлттэй хичээлийн хүрээнд цэргийн штабын даргын баталсан хуваарийн дагуу аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад хичээл сургалтыг “Чөлөөлөх дайн-1945” хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа.<br>Сургалтаар хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, чөлөөлөх дайны эхэлсэн шалтгаан, дайны үйл явц, үр дүн, Монгол улсын тусгаар тогтнолыг баталгаажуулахад уг дайны оруулсан хувь нэмрийн талаарх мэдээлэл хийсэн.<br>Цэргийн штабаас аймгийн Соёл урлагийн газар, Залуучуудын хөгжлийн газартай хамтран 20-25 насны залуучуудын дунд “Зангиагүй” уулзалт арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаар болон цэргийн албаны талаа мэдээ мэдээллийг хүргэж залуучуудад тулгамдаж байгаа асуудлуудын талаар чөлөөт уулзалт, ярилцлагыг зохион байгууллаа хэлэлцлээ.<br>Өсвөр үе, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, үндэсний уламжлалт ёс заншил, зан үйл, тоглоом наадгайг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, сурталчлан таниулах, түүх, соёлын өвийг хайрлан хамгаалах, үндэсний бичиг, хувцас соёлыг түгээх, багаар ажиллах чадварыг суулгах зорилготой “Эх оронч Монгол-Өвлөн наадъя” дэвжээ тэмцээн болон “Эх оронч үзэл-Үндэсний бахархал” сэдэвт илтгэлийн уралдаануудыг зохион байгууллаа. Тус тэмцээнд ерөнхий боловсролын сургуулийн 12 багийн 96 сурагч өрсөлдлөө.<br>Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Бидний бахархал” төслийн хүрээнд хүүхэд залуучуудад эх оронч үзэл, хандлагыг төлөвшүүлэх “Эх оронч 10000” сургалт сурталчилгааны ажлыг Спорт соёл урлагийн менежментийн сургалт, судалгааны төвтэй хамтран зохион байгууллаа. | | |
| 4 | Арга хэмжээ 1.4. Аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг зохион байгуулах, шалгарсан | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Тэмцээний хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, зааврыг боловсруулах | Тус тэмцээнд ЕБ-ын 10 сургуулийн 10 багийн 130 сурагч хамрагдсан | Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 104 жил, “Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил”-ийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгох, эх орон, түүх, соёл, уламжлал, ёс заншлаараа бахархах | Тухайн жилд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баг тамирчдыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнд оролцуулах. | | | | үзлийг төлөвшүүлэх, бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил суулгах зорилготой аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл 2025” цогцолбор тэмцээнийг хоёр үе шаттай зохион байгуулсан бөгөөд тэмцээний нэгдүгээр шатыг 2025 оны 04 дүгээр сарын 21,22-ны өдрүүдэд сумууд дотооддоо зохион байгуулж, хоёрдугаар шатны тэмцээнийг 2025 оны 05 дугаар сарын 09,10-ны өдрүүдэд зохион байгуулж шилдгүүдээ шалгаруууллаа.<br>Тэмцээнийг гарааны өмнө гүйцэтгэх ажиллагаа, маршийн явцад гүйцэтгэх ажиллагаа гэсэн 2 шаттайгаар зохион байгууллаа.<br>Нэгдүгээр шат гарааны өмнөх ажиллагаанд баг тамирчид жагсаалын үзүүлэх тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолт, тасгийн захирагч нарын тэмцээн, гэрийн даалгавар гэсэн төрлөөр өрсөлдсөн бол хоёрдугаар шат маршийн явцад гүйцэтгэх ажиллагаанд баг тамирчид 6 км-ийн марш үйлдэн маршийн явцад нэгдүгээр дасгал гранат шидэлт, хоёрдугаар дасгал ерөнхий цэргийн саад, гуравдугаар дасгал инженерийн саад, дөрөвдүгээр дасгал нормативын цэг, тавдугаар дасгал байр зүйн норматив, зургаадугаар дасгал химийн нормативын дасгалыг гүйцэтгэсэн.<br>Тэмцээний тэргүүн байранд Халиун сумын ЕБС-ын Ж.Мягмарсүрэн тасгийн захирагчтай “Оргил” тасаг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгарч шилжин явах цом, өргөмжлөл, 2000000 төгрөг;<br>Дэд байранд Тонхил сумын ЕБС-ийн Т.Батбилэг тасгийн захирагчтай “Алтан соёмбо” тасаг шалгарч өргөмжлөл, 1500000 төгрөг;<br>Гуттаар байранд Есөнбулаг сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн О.Тамираа захирагчтай “Дөл” тасаг шалгарч шалгарч өргөмжлөл 1000000 төгрөгөөр тус тус шагнагдлаа.<br>Аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цолцолбор тэмцээнд амжилттай оролцсон баг, тамирчдаас сурагчдыг сонгон шалгаруулж Батлан хамгаалахын сайдын А/150 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/254 дүгээр захирамжийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цолцолбор тэмцээнд амжилттай оролцож 13 дугаар байранд шалгарлаа.<br>Тус тэмцээнд 21 аймаг Нийслэлийн 9 дүүргийн нийт 30 баг 2025 оны 06 дугаар сарын 05-07-ний өдрүүдийн хооронд гарааны өмнөх ажиллагаа, маршийн гүйлтийн тэмцээний төрлөөр 2 өдрийн турш олон улсын сургалтын нэгдсэн төв Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн байрлалд өрсөлдлөө. | | |
| **Зорилт 2.** Дайчилгааны нөөцийг тооцох, дүн шинжилгээ хийх, мэдээ судалгааг цаг тухайд нь гаргаж танилцуулах, хугацаат албаны цэрэг татлагын ажлыг зохион байгуулах | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Цэргийн штабыг байлдааны бэлэн | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Цэргийн бүртгэлийг хууль | Цэргийн бүртгэл зохион | “Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө”, “Орон нутгийн цэргийг | Тухайн жилд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх төлөвлөгөө, Орон нутгийн цэргийн төлөвлөгөөнүүдэд оногдуулан бүртгэгдсэн хүн, техникийг дайчилгааны даалгаврын дагуу тогтоосон хугацаанд татан нийлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, дайчилгааны томилгоот бүрэлдэхүүн, хүч хэрэгсэлд тодотгол хийх | | тогтоомж, журмын дагуу зохион байгуулж цэргийн бүртгэлд байх насны буюу 18-50 насны иргэдийг хамруулах | байгуулсан тухай дүн мэдээг нэгтгэн холбогдох байгууллагад төрийн болон албаны нууцын горимын дагуу боловсруулж хүргүүлэх | байгуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөө"-г тодотгон, сумдын орон нутгийн цэргийн отряд, сумангийн хүн, хүч, машин техникүүдийг оногдуулан бүртгэсэн байдалд хяналт, шалгалтын ажлыг 2025 оны хоёрдугаар ээлжийн хугацаат албаны цэрэг татлагын ажлаар хамтатган зохион байгуулж сумдын орон нутгийн цэргийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах томилгоот бүрэлдэхүүн, хүч хэрэгслийг тодотгон нөхөн хангалт хийж ажиллах талаар үүрэг чиглэл өгч ажилласан. "Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө"-г батлуулахаар ажиллаж байна. Дайчилгааны даалгавартай Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 304 дүгээр тусгай салбартай хүн, техникийг оногдуулан бүртгэж бүртгэгдсэн дайчилгааны бэлтгэл үүрэгтний нэр, татан нийлүүлэх техникийн жагсаалт, чанар байдлын судалгаа, цугларах болон шилжүүлэх байр, ангийн угтах байр, байршил зэрэгт тодотгол хийж, тодотгол хийсэн тухай нотломж, харилцан ажиллагааны төлөвлөгөө, оногдуулан бүртгэгдсэн хүн, техникийн жагсаалт, чанар байдлын судалгааг "Монгол Улсын Зэвсэгт хүчний нууцыг хамгаалах журам"-ын дагуу баримт бичгийг боловсруулж, тодотгол хийсэн нотломжийг Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.<br>"Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үед Цугларах байрыг аймгийн “Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар”-т, Шилжүүлэх байрыг аймгийн “Авто тээврийн үндэсний төв”-д зохион байгуулахаар аймгийн Засаг даргын захирамжаар томилгоожуулж, Цугларах, Шилжүүлэх байрын бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулсан.<br>Аймгийн улсын дайчилгааны төлөвлөгөө боловсруулагдан батлагдсантай холбогдуулан сумдад дайчилгааны даалгавар тогтоох, дайчилгааны төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангах талаар сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтын хүрээнд үүрэг чиглэлийг өгч мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан. Сумдын дайчилгааны даалгаврыг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар томилон ажиллаж байна. Завхан аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын цэргийн сургалт бэлтгэлийн үеэр аймгуудын улсын дайчилгаа хариуцсан мэргэжилтнүүдтэй Батлан хамгаалах яамны Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны газрын дарга тусгайлан сумдад дайчилгааны даалгавар хэрхэн тогтоох тухай, дайчилгааны даалгавар тогтоох тухай аймгийн Засаг даргын захирамжийг хэрхэн боловсруулах, дайчилгааны даалгавар тогтоосон танилцуулгыг бэлтгэх талаар мэргэжил, арга зүйн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвлөгөөг өгсөн. Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт сумын дайчилгааны төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай тооцоо судалгааг хэрхэн боловсруулах талаар сургалт, мэргэжил, арга зүйн дэмжлэгийг Батлан хамгаалах яамны Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны газраас үзүүлсэн. Дайчилгааг зохион байгуулахад нөлөөлөх бодит боломж, нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, цэргийн дайчилгааны үеийн удирдлага, дайчилгааны бэлэн байдлын түвшин, дайчилгааны бэлтгэл нөөцийн байдал, цэргийн дайчилгаа явуулах боломж, техникийн судалгаа, төлөвлөгөө батлуулахад шаардагдах лавлах өгөгдөхүүнүүдийг бэлтгэн, сумдад дайчилгааны даалгавар өгсөн. | | |
| 2 | Арга хэмжээ 2.2. Хугацаат цэргийн албаны цэрэг халалт, татлагыг зохион байгуулах; | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Цэргийн алба хаах насны иргэдэд цэргийн албанд зарлан дуудах мэдэгдэх хуудсыг хүргүүлэх | ЗХЖШ-аас ирүүлсэн хяналтын тоонд багтаан хугацаат цэргийн насны залуусыг цэрэг татлагын товчооны эрүүл мэндийн үзлэгт хамруулан тэнцсэн иргэдийг хугацаат | Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны мн/243 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2025 оны мн/05, мн/29 дүгээр тушаалууд, аймгийн Засаг даргын 2025 оны “нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлага явуулах тухай” А/131, А/522 дугаар захирамжуудыг тус тус удирдлага болгон нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ний өдрүүдэд, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг 10 дугаар сарын 03-ны өдрөөс 17-ны өдрүүдэд зохион байгуулж Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгсөн хяналтын тоог хангаж биелүүллээ. | Тухайн жилд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | цэргийн албанд татах | | | |
| **Зорилт 3.** Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 3.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулж, төлөвлөгөөний биелэлт гаргах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ажил үүргээ гүйцэтгэж, биелэлт хангагдсан байна | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг цаг хугацаанд нь боловсруулан батлуулж биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ажиллаж байна. | Тухайн жилд | 100% |
| 2 | Арга хэмжээ 3.2. Төрийн албан хаагчийг ёс зүйг баримтлан ажиллаж удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлүүлнэ | Төрийн албан хаагчийг ёс зүйг баримтлан ажиллаж удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлүүлсэн байдал | 2022 оны үзүүлэлт | Төрийн албан хаагчийг ёс зүйг баримтлан ажиллах | Төрийн албан хаагчийг ёс зүйг баримтлан ажиллаж удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд биелүүлж ажилласан. Тус Цэргийн штабт ирсэн хугацаатай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, биелэлтийг цаг хугацаанд нь гаргаж ажилласан. | Тухайн жилд | 100% |
| 3 | Арга хэмжээ 3.3. Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, хариуцсан асуудлын хүрээнд ирсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь судалж, хариу мэдэгдэнэ | Иргэдэд үзүүлсэн үйлчилгээгээр | Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, хариуцсан асуудлын хүрээнд ирсэн өргөдөл, гомдлыг | Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар сайжирч, иргэн, төрийн албан хаагч хоорондын харилцаа | Цэргийн алба болон хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдын ар гэрээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухай бүр цаг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Цэргийн албан хаагчийн ар гэрээс, орон нутгийн чөлөө хүссэн өргөдөл, цэргийн албанаас хугацаанаас өмнө халуулахыг хүссэн өргөдөл, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлт гаргасан иргэдийн материалыг хүлээн авч анги | Тухайн жилд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хугацаанд нь судалж, хариу мэдэгдэх | | байгууллага болон ЗХЖШ, ХХЕГ-дад уламжилж шийдвэрлүүлэн ажилласан. | | |
| 4 | Арга хэмжээ 3.4. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргийн дагуу боловсруулагдсан албан бичгийг бүртгэлжүүлэн, архивлах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Ажил үүргийн дагуу боловсруулагдсан албан бичгийг бүртгэлжүүлэх | Ажил үүргийн дагуу боловсруулагдсан албан бичгийн архивын нэгж үүсгэсэн байна | Цэргийн штабаас зохион байгуулсан ажил, арга хэмжээний тайлан төлөвлөгөө, явсан болон ирсэн бичгийг бүртгэлжүүлэн ажиллаж байна. | Тухайн жилд | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цэргийн сургуульд элсэн суралцах хүсэлтэй иргэдийг сонгон шалгаруулж элсүүлэх. | Элсэгчдийн хувь | - | Элсэгчдийн тоо | Үндэсний батлан хамгаалах их сургуулийн цэргийн бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт элсэхийг хүсэгчдийг бүртгэн элсэлтийн журмын дагуу ур чадварын шалгалтыг авч 8 иргэнийг элсүүлж ажилласан. | 2025 оны 06 дугаар сард | 100% |
| 2 | Аймгийн ЗДТГ-аас зохион явуулсан цаг үеийн үйл ажилд оролцох, орон нутагт томилолтоор ажиллах. | Оролцсон арга хэмжээ | | | Туульсын хаан Жангар тууль хайлах арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажил арга хэмжээнд оролцож мөн тус арга хэмжээнд зохион байгуулагдсан гал тахих ёслолыг арга хэмжээг зохион байгуулсан. | Тухайн жилд | 100% |
| 3 | Орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцох. | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | - | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгууллагын гаднах ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сэргээн засах ажилд оролцож байгууллагын эргэн тойронд мод тарьсан. | Тухайн жилд | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | БХЯам, ЗХЖШ-аас зохион явуулахаар төлөвлөгдсөн мэргэжлийн сургалтуудад тушаалын дагуу хамрагдах. | Сургалтад хамрагдсан байдал | Цэргийн ухааны бакалавр зэрэгтэй | Боловсролын зэрэг дээшилсэн байх | Үндэсний Батлан хамгаалах их сургуулийн магистрын хөтөлбөрт хамрагдан аюулгүй байдлын дамжаанд суралцаж байгаа. | - | 70% |
| 2 | Цэргийн хэргийн мэдлэгийг дээшлүүлэх. | Цэргийн хэргийн мэдлэгийн түвшин | 2024 оны үзүүлэлт | Цэргийн хэргийн мэдлэгийн түвшин дээшилсэн байна | Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар батлагдсан "Даргын бэлтгэл" сургалтын хөтөлбөрийн дагуу удирдахуйн ухаан, цэргийн сургалт бэлтгэл, албан хэрэг хөтлөлт ба нууцын горим, цэргийн штабын үйл ажиллагаа сэдвийн хүрээнд нийт 48 цагийн хичээл сургалтад хамрагдлаа. | Тухайн жилд | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ДАЙЧИЛГААНЫ ОФИЦЕР ............................................ / Г.МӨНХБАЯР / 2025.12.04

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*